ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 12 өдөр Дугаар А/37 Рашаант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх Их-Ац багийн төвийн шинэ барилгын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баянбаатар (ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичиг: М.Энхтуул (СӨББ-ын эмч)

Гишүүд: Н.Нандин-Эрдэнэ (Санхүү албаны дарга)

Д.Шинэбаяр (Их-Ац багийн Засаг дарга)

Н.Отгончимэг (Байгаль хамгаалагч)

2.Дээрх ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баянбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА Э.МЯГМАРЦОГТ

6706011051

БАТЛАВ:

ЗДТГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯНБААТАР

Их-Ац багийн төвийн барилга барих ажлыг гүйцэтгэх ажлын даалгавар

2025.03.28

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Техникийн тодорхойлолт
1	Их-Ац багийн төвийн барилга	ш	1	20:10-ийн харьцаатай их биений хэсгийг полистрол блокоор өрсөн байна. Армотур төмөр тавьж бүс бетон цутгасан байна. Таазны өндөр 3.0м, гадна тал 5см-ийн зузаантай базалт хөвөн, сайдингаар өнгөлсөн байна. Дотор талыг шавардаж замаск татаж, будгаар будна. Хундаам нь доош 40см ухаж газрын түвшнөөс дээш 40см-ын өндөртэй цутгасан байна.
2	Барилгын шал			Шал нь10см-ийн зузаантай цутгамал, паркетан шалтай байна.
3	Барилгын дээвэр			Дээвэр нь шувуу нуруу хэлбэртэй, сендвичин төмрөөр дээвэрлэсэн байна. 5мм-ийн зузаантай 5:10 харьцаатай квадрат төмрөөр фермер А зангидана.
4	Барилгын хаалга	ш	2	Сайн чанарын материалаар хийгдсэн бүргэд хаалгатай дүйцхүйц байна. Хаалга нь тус бүр шаттай шат нь цутгамал, шатны хамгаалалттай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх зориулалтын налуу шаттай байна. Хаалга тус бүр дээр 3:2 харьцаатай үүдний хэсэгтэй байна.
5	Барилгын цонх	ш	4	150:150см-ийн өргөнтэй цонхтой, цонх нь төмөр битүү хамгаалалтаар хамгаалагдсан байна. Мөн вакум рамтай давхар шилтэй, дулаан алдахгүй бат бөх байна.
6	Хувцас солих өрөө	ш	1	2:4 хэмжээтэй байна.
7	Шитны өрөө	ш	1	2:4 хэмжээтэй байна.
8	Барилгын халаалт			Нам даралттаар халдаг байхаар шийдвэрлэнэ. Тайзны ард 2 пар, цонх тус бүр дээр 1,1 пар байна.
9	Барилгын дотор мантож, гэрэл цахилгаан			Дотор цахилгааны монтаж далд 3,2мм-ийн голчтой олон ширхэгтэй зэс голтой утсаар хийж разитикийг үзэгчидийн зааланд 4ш, шитны өрөөнд 1ш, хувцас солих өрөөнд 1ш тайзан дээр 2ш-ийг тус бүр байрлуулна. Тайзны хэсэгт 2ш, үзэгчдийн зааланд 8ш, хувцас солих өрөөнд 1ш, шитны өрөөнд 1ш, Үүдний 2 хэсэгт 1,1 ширхэг гэрлийг тус тус байрлуулна.
10	Барилга нь тайзны хэсэгтэй байна.			Тайзны өндөр 50см, Тайз нь 4:6 харьцаатай байна.

11	Хяналт хийлгэх зардал	ш	1	Хөвсгөл аймгийн Барилга захиалагчийн хяналтын төвөөр хяналт хийлгэх.